



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: *ДОА-2021/107/СТА-ТШЗ*

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Ухаанбилэг

Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ГИХГ	Гадаадын иргэний харьяатын газар
СС	Сангийн Сайд



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	3
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	3
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	3
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	3
3. Аудитын тайлан.....	4
3.1. Ерөнхий зүйл.....	4
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	4
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	4
3.4. Материаллаг байдал.....	5
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	5
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	7
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	8
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.9. Аудитын илрүүлэлт.....	9
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	9
Аудитын зөвлөмж.....	10
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	10
4. Менежментийн захидал.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	12



1.Хараат бус аудиторын дүгнэлт

ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.Хараат бус аудиторын дүгнэлт

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 189

танай _____ -ны № _____ -т

ГИХГ-ЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ТӨРХҮҮ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. ГИХГ-ын Зүүн бүс дэх газар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 97.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

ДОА-2021/107/СТА-ТШЗ



ᠲᠡᠷᠢᠨ
ᠠᠸᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ
ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠠᠭᠢᠨ
ᠪᠠᠳᠢᠲᠤᠨ
ᠪᠠᠳᠢᠲᠤᠨ

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58259147.20	69498433.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	58259147.20	69498433.40
354	Хангамжийн материал	58259147.20	69498433.40
35410	Бичиг хэргийн материал	1916780.00	1864038.00
35420	Аж ахуйн материал	8685880.00	8685880.00
35440	Түлш, шатах тослох материал	6490270.00	2720680.00
35470	Бусад хангамжийн материал	41166217.20	56227835.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	873479913.58	1106241791.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	873479913.58	1106241791.48
392	Биет хөрөнгө	872077413.58	1082334291.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	736637739.35	740487739.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9993373.36	-31008093.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	241500000.00	361000000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-132975312.88	-70520833.47
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	137611454.89	100399011.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-108697291.35	-42367938.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26636930.00	40870951.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18642733.07	-16526544.98
393	Биет бус хөрөнгө	1402500.00	23907500.00
39301	Програм хангамж	2750000.00	1980000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1347500.00	-1072500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	23000000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	931739060.78	1175740224.88
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	931739060.78	1175740224.88
51	Засгийн газрын хувь оролцоо	931739060.78	1175740224.88
512	Хуримтлагдсан үр дүн	925230005.91	1169231170.01
51210	Өмнөх үеийн үр дүн	925230005.91	925230005.91
51220	Тайланг үеийн үр дүн	0.00	244001164.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6509054.87	6509054.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	931739060.78	1175740224.88



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1167844674.70	1039938248.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	650102774.70	373473398.68
120	Нийтлэг татварын бус орлого	650102774.70	373473398.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	650102774.70	373473398.68
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	650102774.70	373473398.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	517741900.00	666464850.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	512741900.00	666168600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	512741900.00	666168600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5000000.00	296250.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5000000.00	296250.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЫН ДҮН	610821670.96	759771634.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	610821670.96	759771634.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	602069821.40	583571713.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349022031.86	349164914.68
210101	Үндсэн цалин	231155231.86	199420212.84
210102	Нэмэгдэл	77586800.00	89143984.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40280000.00	41238476.90
210104	Урамшуулал	0.00	19362240.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44089523.12	40947424.75
210201	Тэтгэврийн даатгал	29834923.12	21245824.75
210202	Тэтгэмжийн даатгал	3563100.00	4925400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2850700.00	3940300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	713500.00	985100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7127300.00	9850800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18381647.50	22443039.81
210301	Гэрэл, цахилгаан	9015784.50	9286096.93
210302	Түлш, халаалт	8423213.00	12117612.88
210303	Цэвэр, бохир ус	810650.00	889730.00
210304	Байрны түрээс	132000.00	149600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60039549.86	66723992.66
210401	Бичиг хэрэг	4771502.00	4250542.00
210402	Тээвэр, шатахуун	27120730.00	29479430.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	2707610.96	2228164.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4817182.00	5408963.00
210408	Бараа материал актальсны зардал	20622524.90	25356893.00
2105	Нормативт зардал	0.00	879300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	879300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35476359.00	5917700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	1000000.00
210604	Урсгал засвар	35476359.00	4917700.00
2107	Томилолт, зочны зардал	3755800.00	2829400.00
210702	Дотоод албан томилолт	3755800.00	2829400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11656156.00	5708766.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360000.00	360000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	1507600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149056.00	146256.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	44000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2333500.00	2227080.00
210807	Газрын төлбөр	0.00	60600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8769600.00	1363230.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79648754.06	88957176.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6391820.00	11799390.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1526900.00	2603200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	71730034.06	74554586.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8751849.56	176199920.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	1994781.00	3962385.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1994781.00	3962385.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6757068.56	172237535.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6757068.56	172237535.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	557023003.74	280166614.62
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЫН ДҮН	0.00	36165450.52
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	36165450.52
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-36165450.52
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	557023003.74	244001164.10



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	517741900.00	666464850.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	517741900.00	666464850.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	512741900.00	666168600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	512741900.00	666168600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5000000.00	296250.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнгэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5000000.00	296250.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	517741900.00	666464850.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	517741900.00	666464850.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	508990050.44	490264929.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349022031.86	349164914.68
210101	Үндсэн цалин	231155231.86	199420212.84
210102	Нэмэгдэл	77586800.00	89143984.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40280000.00	41238476.90
210104	Урамшуулал	0.00	19362240.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44089523.12	40947424.75
210201	Тэтгэврийн даатгал	29834923.12	21245824.75
210202	Тэтгэмжийн даатгал	3563100.00	4925400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2850700.00	3940300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	713500.00	985100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7127300.00	9850800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20127647.50	20552719.81
210301	Гэрэл, цахилгаан	9015784.50	9286096.93
210302	Түлш, халаалт	10169213.00	10227292.88
210303	Цэвэр, бохир ус	810650.00	889730.00
210304	Байрны түрээс	132000.00	149600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42375722.96	41099024.66
210401	Бичиг хэрэг	4981650.00	4197800.00
210402	Тээвэр, шатахуун	29000000.00	27600160.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	2707610.96	2228164.66
210404	Ном, хэвлэл	100000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5586462.00	7072900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35476359.00	15762700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	4000000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	2950000.00
210604	Урсгал засвар	35476359.00	8767700.00
2107	Томилолт, зочны зардал	3755800.00	2829400.00
210702	Дотоод албан томилолт	3755800.00	2829400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4611846.00	4773456.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1065290.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360000.00	360000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	1507600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149056.00	146256.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	44000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2993500.00	2655000.00
210807	Газрын төлбөр	0.00	60600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9531120.00	15135290.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8004220.00	12532090.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1526900.00	2603200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8751849.56	176199920.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	1994781.00	3962385.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1994781.00	3962385.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6757068.56	172237535.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6757068.56	172237535.10
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	369,372,292.17		369,372,292.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	6,509,054.87	369,372,292.17	0.00	375,881,347.04
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00		0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
C07	Тайланг үеийн үр дүн			555,857,713.74		555,857,713.74
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	6,509,054.87	925,230,005.91	0.00	931,739,060.78
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	6,509,054.87	925,230,005.91	0.00	931,739,060.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	6,509,054.87	925,230,005.91	0.00	931,739,060.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайланг үеийн үр дүн			244,001,164.10		244,001,164.10
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	6,509,054.87	1,169,231,170.01	0.00	1,175,740,224.88



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	666168600.00	494227314.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	666168600.00	494227314.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	662205800.00	490264929.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	474538400.00	349164914.68
210101	Үндсэн цалин	249582400.00	199420212.84
210102	Нэмэгдэл	142565000.00	89143984.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44580000.00	41238476.90
210104	Урамшуулал	37811000.00	19362240.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66492800.00	40947424.75
210201	Тэтгэврийн даатгал	45141200.00	21245824.75
210202	Тэтгэмжийн даатгал	5125400.00	4925400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4940300.00	3940300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1035100.00	985100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10250800.00	9850800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23710800.00	20552719.81
210301	Гэрэл, цахилгаан	11777200.00	9286096.93
210302	Түлш, халаалт	10894000.00	10227292.88
210303	Цэвэр, бохир ус	890000.00	889730.00
210304	Байрны түрээс	1496000.00	1496000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41035700.00	41099024.66
210401	Бичиг хэрэг	4197800.00	4197800.00
210402	Тээвэр, шатахуун	27467700.00	27600160.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2297300.00	2228164.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7072900.00	7072900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33767700.00	15762700.00
210601	Багаж, техник хэрэгсэл	4000000.00	4000000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3000000.00	2995000.00
210604	Урсгал засвар	26767700.00	8767700.00
2107	Томилолт, зочны зардал	2880000.00	2829400.00
210702	Догоод албан томилолт	2880000.00	2829400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4808900.00	4773456.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360000.00	360000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1507600.00	1507600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146800.00	146256.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45200.00	44000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2655000.00	2655000.00
210807	Газрын төлбөр	94300.00	60600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14971500.00	15135290.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12368300.00	12532090.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2603200.00	2603200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3962800.00	3962385.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3962800.00	3962385.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3962800.00	3962385.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	666168600.00	666168600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	666168600.00	666168600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	666168600.00	666168600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	296250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	296250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	296250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	132460.00
210402	Тээвэр, шатахуун	132460.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	163790.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	163790.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	296250.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	296250.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	296250.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00



3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Төрхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 17-ноос 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12/09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Удирдлагын шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар удирдлагын манлайллыг хангах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх;
- Хүний нөөцийн удирдлагын шилдэг арга барилыг хэрэглэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар оновчтой, цомхон, чадварлаг бүтцийг бий болгох, хөгжүүлэх;
- Олон улсын болон гадаад орны ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэд харилцан зорчих нөхцөлийн талаарх олон улсын болон хоёр талт гэрээний хэрэгжилтийг хангах;
- Нээлттэй, ил тод, шуурхай, чанартай, хүртээмжтэй ажил, үйлчилгээ үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ГИХГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2020 онд ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт хийгдээгүй байна.



ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 611,986.9 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 12,239.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 759,771.6 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 15,195.4 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 244,001.1 мянган төгрөгөөр буюу 26.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авто тээврийн хэрэгслийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	58,259.10	69,498.40	11,239.30
Үндсэн хөрөнгө	873,479.90	1,106,241.80	232,761.90
Хуримтлагдсан элэгдэл	271,656.20	161,495.90	(110,160.30)
Нийт хөрөнгө	931,739.00	1,175,740.20	244,001.20
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	931,739.00	1,175,740.20	244,001.20
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	931,739.00	1,175,740.20	244,001.20

Бараа материалын дансны үлдэгдэл 69,498.4 мянган төгрөг болж 11,239.3 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бараа материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,106,241.8 мянган төгрөг болж 232,761.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд шинэ автомашин авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,175,740.2 мянган төгрөг болж 244,001.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нэмэгдсэн хөрөнгийн дүнгээр өссөн байна.



2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 197,096.7 мянган төгрөгөөр буюу 16.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 345,819.7 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 147,784.6 мянган төгрөгөөр буюу 19.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал шилжүүлгийн зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 666,168.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 666,168.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 666,168.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэх 666,168.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 666,168.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 493,931.0 мянган төгрөгийг зарцуулж 172,237.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 493,931.0 мянган төгрөг буюу 74.1 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас нэмэлт санхүүжилтийн дансанд 296.2 мянган төгрөгийг хашаа засварлаж, сайжруулахад зориулж дэмжлэг үзүүлсэн байна. Уг санхүүжилтийг тээвэр, шатахууны зардалд 132.4 мянган төгрөг, материалын зардалд 163.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих нийт 149 мэдээллээс хугацаа хоцроосон болон байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.



3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 37,884.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	8,242.1	1	8,242.1	-	-	-
Албан шаардлага	1	29,642.8	1	29,642.8			
Нийт дүн	4	37,884.9	4	37,884.9			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,068.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил байхгүй

Аудитын зөвлөмж

Аудитаар кассын тайланг Сангийн Сайдын 2012 оны 276 дугаар тушаалтаар батлагдсан маягтын дагуу хөтөлж ажиллах зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Кассын бүртгэл, хөтлөлтийг анхааралдаа авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Кассын тайлантай холбоотой

- 1.1. Илрүүлэлт: Аудитаар шалгагдагч байгууллага нь арилжааны банкин дахь дансаараа дамжуулан 5068.02 мянган төгрөгийг авч зарцуулахдаа Сангийн Сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу тайланг гаргаж ажиллаагүй байна.
- 1.2. Эрсдэл: Зориулалт бусаар зарцуулагдах
- 1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн Сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Мөрдөж ажиллана.



Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дорнод аймгийн ГИХГ-ын Зүүн бүс дэх газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ДОА-2021/107/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	ГИХГ-ын Зүүн бүс дэх газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Кассын тайланг СС-ын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-аар батлагдсан маягтын дагуу илэрхийлээгүй.	5,068.2	Зөвлөмж	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Д.Төрхүү, Х.Хэрлэн-Урсгал
ДҮН		5,068.2			